



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/06/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2022 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т. Мөнхзул Утас: 7036-2442 Цахим хаяг: Munkhzult@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл	9
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	20
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	22
3.8. Аудитын гол асуудал	23
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
4. Аудитын илрүүлэлт	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УОК	Улсын онцгой комисс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ЗДНХ	Засаг Даргын нөөц хөрөнгө



ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц. ДАРХАНБААТАР ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № ЦА 2022/06-НА-СТА-ТТЗ

Танай _____-нийг

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Жавхланта сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жавхланта сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	376,039.80	502,803.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	37,129.20	104,242.50
33	АВЛАГА	196,150.50	216,194.60
35	БАРАА МАТЕРИАЛ	142,760.20	182,366.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,484,538.00	3,674,673.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,484,538.00	3,674,673.70
39200	Биет хөрөнгө	3,467,895.60	3,659,680.00
39300	Биет бус хөрөнгө	16,642.40	14,993.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,860,577.80	4,177,477.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,538.20	91,638.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,538.20	91,638.30
41300	Өглөг	1,538.20	91,638.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,859,039.60	4,085,839.00
51	Засгийн газрын хувь оролцоо	3,859,039.60	4,085,839.00
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,314,337.20	1,314,337.20
51200	Хуримтлагдсан үр дүн	1,364,178.20	1,590,977.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,180,524.20	1,180,524.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,860,577.80	4,177,477.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,314,158.80	3,141,466.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	51,969.40	92,431.10
110	Орлогын албан татвар	37,402.80	20,315.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	37,402.80	20,315.60
113	Хөрөнгийн албан татвар	450	44,306.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	14,116.60	27,809.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	415,018.10	593,229.90
120	Нийтлэг татварын бус орлого	415,018.10	593,229.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,847,171.30	2,455,805.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,128,157.20	2,705,488.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,128,157.20	2,705,488.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,221,699.50	2,623,880.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,288,815.40	1,448,781.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,592.70	183,884.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	208,776.00	272,605.30
2104	Хангамж, бараа материалын зардал	121,628.20	85,134.90
2105	Нормативт зардал	83,678.20	235,591.80

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,806.50	50,142.40
2107	Томилолт, зочны зардал	2,380.60	1,933.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,056.10	16,897.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	322,965.70	328,909.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	906,457.70	81,608.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	186,001.60	435,978.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	82,089.00	206,432.70
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	103,912.70	229,545.80

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,755,126.90	3,755,126.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,755,126.90	3,755,126.90
9	Тайлант үеийн үр дүн	103,912.70	103,912.70
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,859,039.60	3,859,039.60
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,859,039.60	3,859,039.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,859,039.60	3,859,039.60
19	Тайлант үеийн үр дүн	229,545.80	229,545.80
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,085,839.00	4,085,839.00

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,930,473.10	2,556,781.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	54,138.30	92,431.10
110	Орлогын албан татвар	39,571.70	20,315.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	39,571.70	20,315.60
113	Хөрөнгийн албан татвар	450	44,306.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	14,116.60	27,809.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,766.20	3,184.90
1181	Газрын төлбөр	6,143.20	18,307.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,207.20	6,316.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,736.00	102,196.70
120	Нийтлэг татварын бус орлого	24,736.00	102,196.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,851,598.80	2,362,153.30
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,815,983.90	2,354,026.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,815,983.90	2,354,026.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,905,271.70	2,272,417.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,293,007.00	1,421,691.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,339.80	182,360.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	210,459.60	272,227.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60,851.10	68,787.80

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	76,872.40	199,640.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,337.20	37,464.40
2107	Томилолт, зочны зардал	2,380.60	1,933.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,186.10	10,144.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,837.90	78,168.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	910,712.20	81,608.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	114,489.20	202,755.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	137,831.90	131,641.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	137,831.90	131,641.70
2200	Дотоод эх үүсвэрээр	137,831.90	131,641.70
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(137,831.90)	(131,641.70)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(64,000.00)	(4,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	64,000.00	4,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(87,342.70)	67,113.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	124,471.80	37,129.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,129.20	104,242.50

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,150,594.4	2,091,217.9	59,376.5	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,060,917.4	2,013,059.0	47,858.4	97.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,026,603.5	1,987,691.3	38,912.2	98.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,338,406.6	1,322,899.4	15,507.2	98.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,522.3	171,876.0	5,646.3	96.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	269,351.3	265,956.4	3,394.9	98.7
2104	Хангамж, бараа материалын зардал	53,110.9	53,074.6	36.3	99.9
2105	Нормативт зардал	78,155.5	66,439.8	11,715.7	85.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,976.0	59,883.6	1,092.4	98.2
2107	Томилолт, зочны зардал	1,854.8	1,753.0	101.8	94.5

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,552.8	6,641.6	911.2	87.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,673.3	39,166.8	506.5	98.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,313.9	25,367.7	8,946.3	73.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,313.9	25,367.7	8,946.3	73.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,677.0	74,159.0	11,518.0	86.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4,000.0	4,000.0	0.0	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,150,594.4	2,155,883.5	-5,289.1	100.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,288,938.9	1,252,298.4	36,640.5	97.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	817,860.0	813,297.3	4,562.7	99.4
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,881.8	15,251.6	6,630.2	69.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	21,913.7	75,036.2	(53,122.5)	342.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	20,501,926.0	20,501,926.0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	85,167,475.0	85,167,475.0	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	112	112		
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	408	402		
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	300	278		
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	108	124		
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	0	4,324.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	363,381.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	361,985.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	340,813.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,792.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,484.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,270.6
2104	Хангамж, бараа материалын зардал	16,100.3
2105	Нормативт зардал	133,200.7

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,280.5
2107	Томилолт, зочны зардал	180.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,503.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,001.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,172.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,600.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,572.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,396.0
2200	Дотоод эх үүсвэрээр	1,396.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	363,281.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	363,281.5
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,584.5
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,476.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,521.8
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	239,698.5
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(100.0)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /Жавхлант сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт гүйцэтгэл, нягтлан болох бүртгэлийн анхан шатны бүрдүүлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/47 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жавхлант сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг *“Төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд ил тод, шуурхай хүргэж, мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны байгууллага болох.”* гэж тодорхойлжээ.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,705,488.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 40,582.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 30,436.7 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 37,129.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 104,242.5 мянган төгрөг болж, 67,113.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	37,129.1	104,242.5	67,113.4	64.3
Дүн	37,129.1	104,242.5	67,113.4	64.3

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан ОНХО-ын дансанд 19,075.0 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 15,203.1 мянган төгрөг, СХС-ийн дансанд 69,964.4 мянган төгрөг зэрэг нийт 104,242.5 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 196,150.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 216,194.6 мянган төгрөг болж, 20,044.1 мянган төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	30.2	30.2	-
Татаас санхүүжилтийн авлага	1,438.3	-	(1,438.3)
Зээлийн хүүгийн авлага	10,106.9	4,282.8	5,824.1
Байгууллагаас авах авлага	-	93,952.4	93,952.4
Хувь хүмүүсээс авах авлага	2,293.4	2,293.4	-
Зээлийн авлага	182,281.7	115,635.8	(66,645.9)
Дүн	196,150.5	216,194.6	20,044.1

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн төв ажиллагчидтай холбогдсон авлага 30.2 мянган төгрөг
- Зээлийн 115,635.8 мянган төгрөг, зээлийн хүүгийн 4,282.8 мянган төгрөг зэрэг нийт 119,918.6 мянган төгрөгийн СХС-тай холбоотой авлагууд тус тус тайлагнагдсан байна.
- ОНЕО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 2,293.4 мянган төгрөг /тооцоо нийлсэн акт байхгүй, эзэн тодорхойгүй/,
- Сумын ЭМТ нь 93,952.4 мянган төгрөгийн ЭМДС-аас авах төлбөртэй үйлчилгээний авлагууд тус тус тайлагнагдсан байна.

Авлагын дансны үлдэгдэлд 2,293.4 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн итгэлийн зээлийн авлага бүртгэгдсэн бөгөөд авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 142,760.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 182,366.5 мянган төгрөг болж, 39,606.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	19,986.1	41,845.5	21,859.4
Эм боох материал	16,849.2	11,665.1	(5,184.1)
Бэлэн бүтээгдэхүүн	10,112.3	13,770.0	3,657.7
Бичиг хэргийн материал	9,617.1	8,966.2	(650.9)
Аж ахуйн материал	81,706.5	92,869.0	11,162.5
Сэлбэг хэрэгсэл	1,310.0	1,355.0	45.0
Барилгын засварын материал	2,480.0	4,266.1	1,786.1

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүнсний материал	278.9	2,416.3	2,137.4
Бусад хангамжийн материал	420.0	5,213.3	4,793.3
Дүн	142,760.1	182,366.5	39,606.4

Материалын дансны үлдэгдэл 39,606.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 455,884.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, хандив, тусламжаар 45,235.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан зэрэг нийт 501,119.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 461,512.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд 34,405.2 мянган төгрөгийн,
- Цэцэрлэг тайлант онд 12,386.2 мянган төгрөгийн,
- Эрүүл мэндийн төв 32,841.2 мянган төгрөг
- Соёлын төв нь 5,301.0 мянган төгрөг
- ЗДТГ нь 14,830.0 мянган төгрөг
- ИТХ 2,168.0 мянган төгрөг гэх мэт.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 4,419,821.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 4,799,362.3 мянган төгрөг болж, 379,540.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	2,434,050.7	2,765,891.8	331,841.10
Авто-тээврийн хэрэгсэл	147,740.8	147,740.8	-
Машин тоног төхөөрөмж(компьютер)	441,798.9	453,108.6	11,309.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	213,621.9	216,644.4	3,022.4
Дуусаагүй барилга байгууламж	163,621.2	50,000.0	(113,621.1)
Бусад үндсэн хөрөнгө	998,760.0	1,146,068.5	147,308.5
Программ хангамж	8,275.0	7,955.0	(320.0)
Бусад биет бус хөрөнгө	11,953.2	11,953.2	0
Дүн	4,419,821.7	4,799,362.3	379,540.6

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ **379,540.6** мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 57,482.7 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Соёлын төвийн их засварын 356,020.0 мянган төгрөгийг капиталжуулсан, аймаг, сум ОНХС-ийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 204,986.0 мянган

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

төгрөгийн гудамжны гэрэлтүүлэг, зам засвар, тоглоомын талбай, Жавхлант угтах хаалга зэргийг шилжүүлэн авч, дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 113,621.1 мянган төгрөгийн барилга болон 6,452.9 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг шилжүүлэн бүртгэж, сумын ИТХ-ын 2021 оны 39 дүгээр тогтоолоор 118,874.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, акталж устгаснаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ТТЗ-ын үндсэн хөрөнгийн тодруулга тайланд акталсан 24,843.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг худалдсанаар тайлагнасан.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 1,538.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 91,683.3 мянган төгрөг болж 90,100.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	-	28,394.5	28,394.5	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	63,243.8	63,243.8	-
Байгууллагад төлөх өглөг	100.0	-	(100.0)	-
Татаас санхүүжилтийн шилжүүлгийн өглөг	1,438.2	-	(1,438.2)	-
Дүн	1,538.2	91,638.3	90,100.1	-

Нийт өр төлбөрийн үлдэгдэлд ЭМДС-ийн санхүүжилтийн дутуугаас сумын ЭМТ-ийн цалингийн өглөг **28,394.5** мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг **63,243.8** мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3,860,577.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 4,177,477.3 мянган төгрөг болж, 229,545.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,314,337.2	1,314,337.2	-	-
Хуримтлагдсан үр дүн	1,364,178.2	1,593,724.0	229,545.8	14.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,180,524.2	1,180,524.2	-	-

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн	3,860,577.8	4,177,477.3	229,545.8	5.6
------------	--------------------	--------------------	------------------	------------

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Сумын ЗДТГ 1000,0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр сумын ЗДТГ 1,075.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 5,824.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Сумын 1 дүгээр цэцэрлэг нь нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан цагийн бүртгэлээр баталгаажаагүй байхад эрхлэгч С.Оюунчимэгт 279.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс, нягтлан бодогч Ц.Ундраад хавсран гүйцэтгэж буй цалинг үндэслэлгүй нэмж 117.4 мянган төгрөгийг тус тус илүү олгосон,
- Сумын ЗДТГ нь 4 албан хаагчид 990.9 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн сангаас олгосон,
- Төсөвт зайлшгүй шаардлага үүсээгүй байхад урсгал зардлыг 4,437.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн тодотгол хийсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 12 сарын 05 дугаар тогтоолоор Жавхлант сум нь тайлант онд 106,740.5 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 119,591.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 12.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ХХОАТатвар	7,556.80	9,056.60	1,499.80	119.8
2	Хөрөнгийн татвар	1,500.00	1,915.90	415.90	127.7

**Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

3	Хадгаламжийн хүүгийн орлого	6,628.9	9,342.90	2,714.00	140.9
4	Бууны албан татвар	500	776	276.00	155.2
5	Малын тоо толгойн албан татвар		43,530.40	43,530.40	-
6	Улсын тэмдэгтийн хураамж	2,000.00	1,962.30	(37.70)	98.1
7	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	24,000.00		(24,000.00)	-
8	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,500.00	1,222.60	(277.40)	81.5
9	Газрын төлбөр	8,520.00	8,348.50	(171.50)	98.0
10	Дуудлага худалдаа	15,000.00	9,959.40	(5,040.60)	66.4
11	Ойн нөөц ашигласны төлбөр	34.8	34.8	-	100.0
13	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	4,500.00	6,281.50	1,781.50	139.6
14	Торгуулийн орлого	15,000.00	14,580.50	(419.50)	97.2
15	Бусад орлого	20,000.00	12,580.00	(7,420.00)	62.9
	Нийт дүн	106,740.5	119,591.6	12,851.1	112.0

Орлогын төлөвлөгөө 12,851.1 мянган төгрөгөөр давж биелсэн нь хувь хүний орлогын албан татвар 1,499.8 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 43,530.4 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 2,714.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн татвар, 415.9 мянган төгрөгөөр, бууны албан татвар 276.0 мянган төгрөгөөр, байгалийн ургамал нөөц ашигласны төлбөр 1,781.5 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн болон газрын төлбөр 171.5 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдаа 5,040.6 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 37.7 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 24,000.0 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 277.4 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 419.5 мянган төгрөгөөр, нэр зааж ангилагдаагүй орлого 7,420.0 мянган төгрөгөөр тус тус тасарсантай холбоотой байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давсан орлого

- Малын тоо толгойн албан татварыг төлөвлөөгүй боловч гүйцэтгэлээр 43,530.4 мянган төгрөг төвлөрүүлсэн.
- Хадгаламжийн хүүгийн орлого 2,714.0 мянган төгрөгөөр давсан нь иргэдийн үл хөдлөх хөрөнгийн борлуулалтаас шалтгаалсан байна.

Тасарсан орлого:

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийг өмнөх жилүүдийн гүйцэтгэлийг үндэслэн хэт өндрөөр төлөвлөснөөс тайлант онд орлого төвлөрүүлээгүй байна.
- Газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөө 5,040.6 мянган төгрөгөөр тасарсан нь газрын дуудлага худалдаа хийгдсэн боловч хуулийн хугацаанд төлбөрөө барагдуулаагүйгээс шалтгаалсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,085,720.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,085,720.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 07 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 621,336.2 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 69,783.3 мянган төгрөг, ЭМДС-аас санхүүжих 21,881.8 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 1,194,584.5 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 05 дугаар тогтоолоор сумын төсвийн орлогыг 97,220.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,000.0 мянган төгрөг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 15,893.7 мянган төгрөг, сумын урьд оны дансны үлдэгдэл 15,000.0 мянган төгрөг, СХС-ын 5,020.0 мянган төгрөгийн зэрэг нийт 2,041,719.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 16 дугаар тогтоолоор тус суманд аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 5,000.0 мянган төгрөгөөр, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 51,315.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаар тогтоолоор орлогын төлөвлөгөөг 9,520.5 мянган төгрөгөөр нэмж сумын төсвийг **2,107,555.2** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/372 дугаар захирамжаар ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийгдэж, сумын төсөв **2,150,594.4** мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 2,150,594.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,060,917.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 85,677.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 4,000.0 мянган төгрөгийг СХС-ийн эргэн төлөгдөх зээл, үйл ажиллагааны зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлын 626,336.2 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 106,740.5 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 30,893.7 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 5,020.0 мянган төгрөгийг СХС-ийн эх үүсвэрээс, 69,783.3 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс, 21,881.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,288,938.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,000.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр аймгаас авах санхүүгийн дэмжлэг 626,336.2 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,288,938.9 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс

15,000.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 102,177.8 мянган төгрөг, ОНХС-аас 69,783.3 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 73,961.2 мянган төгрөг, ЭМД-ын сангаас 15,251.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,075.0 мянган төгрөг зэрэг нийт 2,192,524.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,091,217.9 мянган төгрөг буюу 97.2 хувьтай тайлагнагдсан нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон зэргээс шалтгаалж хэмнэгдсэн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 15,507.2 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 5,646.3 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,394.9 мянган төгрөгөөр, бараа материалын зардал 36.3 мянган төгрөгөөр, нормативт зардал 11,715.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,092.3 мянган төгрөгөөр, томилолтын зардал 101.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 911.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 506.5 мянган төгрөг, тэтгэмж, урамшуулал 8946.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт батлагдаагүй бөгөөд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 7 төсөл, арга хэмжээнд 85,677.0 төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 74,158.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ЗДНХ-өөс 5,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчдаас 63,476.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 48,521.8 мянган төгрөг, иргэн хуулийн этгээдээс ковид-19 цар тахалтай тэмцэхэд өгсөн хандив 6,584.5 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 239,698.4 мянган төгрөг зэрэг нийт 363,281.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин хөлсөнд 98,792.2 мянган төгрөг, НДШ-д 10,484.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 6,270.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 16,100.2 мянган төгрөг, нормативт зардалд 133,200.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 33,280.5 мянган төгрөг, албан томилолтын зардалд 180.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний

зардалд 3,503.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 39,001.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд 19,600.0 мянган төгрөг, биет ба биет бус хөрөнгө худалдан авахад 1,396.0 мянган төгрөг зэрэг нийт 361,909.3 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 1,572.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

- Ковид 19 цар тахлын хүрээнд иргэд, аж ахуй нэгжийн хандиваар нийт 6,584.5 мянган төгрөгийн хандивыг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.
- ОНЕО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 2,293.4 мянган төгрөгийн /*тооцоо нийлсэн акт байхгүй, эзэн тодорхойгүй*/ зээлийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт № 8 ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон
1	Засаг даргын тамгын газар	151	130	21
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	148	3
3	Эрүүл мэндийн төв	151	135	16

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Соёлын төв	151	147	4
5	ТТЗ	179	163	16
	Нийт дүн	783	723	60

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 783 мэдээллээс 723 мэдээллийг хугацаанд нь 60 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант хугацаанд сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт № 9 ТТЗ-ийн харьяа байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлт

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэсэн хувь
1	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	59,904.0	59,811.0	0.2
2	Засаг даргын Тамгын газар	361,508.2	359,522.9	0.5
3	Соёлын төв	111,175.4	110,960.3	0.2
	Нийт дүн	532,587.6	530,294.2	0,4

ТТЗ-ийн харьяа дээрх 4 байгууллагын тайлант оны үйл ажиллагаанд 532,587.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 530,294.2 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.6 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: "... батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 18,512.2 мянган төгрөгийн зөрчилд 5,410.8 мянган төгрөгийн 6 албан шаардлага, 13,101.2 мянган төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс 2 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт № 10 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	6	5,410,8	6	5,410,8	100
Зөвлөмж	7	13,101.2	5	3,450.0	71.4
Нийт дүн	13	103,263.5	11	92,105.5	84.6

Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах болон төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсөвт тодотгол хийхгүй байх зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 6 төсвийн байгууллага, орон нутгийн төсөл, сангийн 2, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага, 2 төсөл санг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 2 байгууллагуудын санхүүгийн тайланд тус бүр "Зөрчилгүй" дүгнэлт өгсөн байна.

Жавхлант сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 133,693.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 25,243.6 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 397.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 4,936.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 103,116.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 85,905.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 24,843.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 4,936.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 56,125.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

4.1 Залруулга.

- Сумын ТТЗ-ын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайланд акталсан 24,843.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг худалдсанаар тайлагнасан алдааг аудитын явцад залруулав.

4.2 Албан шаардлага

1. Аймгийн төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр зайлшгүй шаардлага үүсээгүй байхад буюу сумын Соёлын төв, ЗДТГ зэрэг байгууллагуудын урсгал зардлыг 4,936.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийсэн байна.

Уг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 34.2.2: “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхээр төсөвт тодотгол хийхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, тооцоололд үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс ЗДТГ нь цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмж, урамшууллын 990.9 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлж байх.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Бараа материалын 55,134.2 мянган төгрөгийн худалдан авалтыг холбогдох үзүүлэлтийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Үүнд:

Жавхлант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Сумын ЗДТГ 14,830 мянган төгрөг, ЭМТ 32,841.2 мянган төгрөг, ИТХ 2,162.0 мянган төгрөг, Соёлын төв 5,301.0 мянган төгрөг.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримт /хүчин төгөлдөр болон төлбөрийн цахим баримт/-ыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
3	Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад буюу Соёлын төв, ЗДТГ-ын урсгал зардлыг нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийсэн.	1	4,936.8					1	4,936.8		
8	Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс ЗДТГ нь цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг санхүүжүүлсэн	1	990.9						ё	1	990.9
10	Сумын ТТЗ-ын санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайланд акталсан машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг худалдсанаар тайлагнасан.	1	24,843.2	1	24,843.2						
	Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй.	1	55,134.2							1	55,134.2
	Дүн	4	85,905.1	1	24,843.2			1	4,936.8	2	56,125.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчиж батлагдсан төсвийг 10-аас доош хувиар хэмнээгүй.	1						1			
2	Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1						1			
	Дүн	2						2			
	Нийт дүн	6	85,905.1	1	24,843.2			3	4,936.8	2	56,125.1